



**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН ЯАМ**

**“ГЭМТ ЭТГЭЭД ШИЛЖҮҮЛЭХ ТУХАЙ МОНГОЛ УЛС БОЛОН БҮГД НАЙРАМДАХ
КИРГИЗ УЛС ХООРОНДЫН ГЭРЭЭ”-Г БАЙГУУЛСНААР МОНГОЛ УЛСАД
ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ, ҮР ДАГАВРЫН ТАЛААРХ ДҮН ШИНЖИЛГЭЭ**

Улаанбаатар хот
2025 он

**“ГЭМТ ЭТГЭЭД ШИЛЖҮҮЛЭХ ТУХАЙ МОНГОЛ УЛС БОЛОН БҮГД НАЙРАМДАХ
КИРГИЗ УЛС ХООРОНДЫН ГЭРЭЭ”-Г БАЙГУУЛСНААР МОНГОЛ УЛСАД
ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ, ҮР ДАГАВРЫН ТАЛААРХ ДҮН ШИНЖИЛГЭЭ**

Ерөнхий мэдээлэл

Монгол Улсын гадаад харилцаа өргөжин хөгжихийн хирээр иргэдийн гадаадад суралцах, ажиллах болон бизнес, аялалын зорилгоор харилцан зорчих явдал нэмэгдэж байгааг харгалзан монголчууд ихээр зорчиж, амьдарч, ажил хөдөлмөр эрхэлдэг улс орнуудтай эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай гэрээ, хэлэлцээр байгуулах асуудалд тус яамнаас анхаарал хандуулан ажиллаж байна.

Дэлхийн улс орнуудад бүс нутгийн хэмжээнд гэмт хэрэгтэй хамтран тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, мөн зохион байгуулалттайгаар, нууц, далд аргаар, хил дамнаж үйлдсэн гэмт хэргийн үйлдлийн арга, хэлбэрийг илрүүлэх, таслан зогсоох, гэмт хэрэг үйлдсэн гэмт буруутай этгээдийг эрэн сурвалжлах, олж тогтоох, улмаар эрүүгийн ял шийтгэл эдлүүлэх зорилгоор бусад улс орны холбогдох хуулийн байгууллагуудтай хамтран ажиллах хэрэгцээ шаардлага нэмэгдсээр байна.

Мөн иргэдийн шилжилт хөдөлгөөн, тэр дундаа манай улсын иргэдийн гадаад улсад зорчих тоо жил ирэх тусам өсөж байгаатай холбоотойгоор гадаад улсад гэмт хэрэг, зөрчилд холбогдох, нөгөө талаас гэмт хэрэг, зөрчилд өртсөний улмаас амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд нь хохирол учрах явдал нэмэгдсээр байгаа энэ цаг үед иргэдийнхээ хууль ёсны эрх ашиг, сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг нь сэргээх зэрэг асуудлыг нэн тэргүүнд авч үзэх зайлшгүй шаардлагатай юм.

Тухайбал, сүүлийн 3 жилийн хугацаанд манай улсын нийт **3037 иргэн** (2022 онд 2018 иргэн, 2023 онд 858 иргэн, 2024 онд 161 иргэн) Бүгд Найрамдах Киргиз Улсад зорчсон бол Киргиз Улсын нийт **4362 иргэн** (2022 онд 808 иргэн, 2023 онд 1582 иргэн, 2024 онд 1972 иргэн) манай улсад зорчсон байна.

Мөн 2025 оны 6 дугаар сарын байдлаар манай улсын 150 гаруй иргэн Бүгд Найрамдах Киргиз Улсад ажил хөдөлмөр эрхлэх, суралцах зорилгоор оршин сууж байгаа бол Киргиз Улсын 75 иргэн (албан хэргээр 2, хөрөнгө оруулагчаар 28, хөдөлмөр эрхэлж байгаа 30, суралцаж байгаа 5, гэр бүл болсон 5, хувийн бусад хэргээр 5 иргэн) ажил хөдөлмөр эрхлэх, суралцах зорилгоор болон гэр бүл болсон зэрэг шалтгааны улмаас манай улсад оршин сууж байна.

Түүнчлэн, Бүгд Найрамдах Киргиз Улсад улсын хилийг хууль бусаар нэвтэрсэн хэргээр хорих ял эдэлж байгаа 1 иргэн, Интерполын шугамаар эрэн сурвалжлагдаж байгаад саатуулагдсан 1 иргэн тус тус байгаагаас гадна хоёр улсын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий байгууллагуудын хамтын ажиллагааны хүрээнд өнгөрсөн хугацаанд Интерполын шугамаар эрэн сурвалжлагдаж байсан Киргиз Улсын 1 иргэн (2024 он)-ийг манай улс шилжүүлэн өгсөн бол Киргиз Улс манай улсын 2 иргэн (2024, 2025 он)-ийг Монгол Улсад тус тус шилжүүлэн өгсөн гэсэн статистик мэдээлэл байна.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн¹ 7 дугаар зүйл (*Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ерөнхий чиглэлийг хэрэгжүүлэх*)-ийн 7.2 дахь хэсэгт “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ерөнхий чиглэлийн хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:” гээд 7.2.4 дэх заалтад “... Хүний эрх, эрх чөлөө, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, хуулиар олгогдсон эрхээ хэрэгжүүлэх баталгааг бүрдүүлэх” гэж, мөн хуулийн 25 дугаар зүйл (*Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар Засгийн газрын бүрэн эрх*)-ийн 25.1 дэх хэсэгт “Засгийн газар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:” гээд 25.1.9 дэх заалтад “... Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх, мэргэшсэн нэгж, мэргэжилтэн бэлтгэх” гэж тус тус заасан.

Мөн Эрүүгийн хуулийн² 1.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын иргэн, тус улсад байнга оршин суудаг харьяалалгүй хүн гадаад улсад энэ хуульд заасан гэмт хэрэг үйлдэж, тухайн гэмт хэрэгт нь эрүүгийн хариуцлага хүлээлгээгүй бол энэ хуулиар эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.” гэж, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь гэмт хэрэг хаана гарсныг үл харгалзан энэ хуулийн дагуу явагдана.” гэж заажээ.

Түүнчлэн, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн³ 42.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Гадаад улсын нутаг дэвсгэрт мэдүүлэг авах, үзлэг, нэгжлэг, туршилт хийх, эд хөрөнгө хураан авах болон энэ хуульд заасан эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах шаардлагатай бол уг асуудлыг эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай болон олон улсын бусад гэрээ, хэлэлцээрийн дагуу гүйцэтгэнэ.” гэж, 42.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүх, прокурор, мөрдөгч нь гадаад улсын холбогдох байгууллага, албан тушаалтны мөрдөн шалгах ажиллагаа явуулах тухай хүсэлтийг энэ хуульд заасан нийтлэг журмын дагуу биелүүлнэ.” гэж тус тус заасан.

Монгол Улсын хэмжээнд хар тамхи, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэг 2023 онд 238, 2024 онд 252 бүртгэгдсэн нь өмнөх оноос 5.9 хувиар (*тоогоор 14*) өссөн үзүүлэлттэй байна. Кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн тухайд 2023 онд 388, 2024 онд 406 тус тус бүртгэгдсэн нь мөн адил өмнөх оноос 4.6 хувиар (*тоогоор 18*) өссөн үзүүлэлттэй байгаа бөгөөд энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох чиглэлээр бүс нутгийн төдийгүй олон улсын цагдаа, хууль сахиулах байгууллагуудтай түргэн, шуурхай хамтран ажиллах хэрэгцээ шаардлагыг бий болгож байна.

Мөн цахим орчинд үйлдэгдэж буй залилан, хууль бус мөрийтэй тоглоом, луйвар, садар самууныг сурталчлах, фэйсбүүк олон нийтийн сүлжээнд хуурамч, хаалттай группүүдийг олноор нээж иргэдээс урьдчилгаа төлбөр авч, садар самуун бичлэг хийж зарах, бүртгэлгүй дугаар ашиглан зар байрлуулан бусдын биеийг үнэлүүлэх зэргээр хүн худалдаалах гэмт хэрэг зохион байгуулалттай хэлбэрт шилжиж байгаа бөгөөд гэмт этгээдийг эрэн сурвалжилж, буцаан авчрах замаар хэрэг бүртгэх, мөрдөн шалгах ажиллагаа явуулж буй энэ төрлийн гэмт хэргүүдийг шийдвэрлэх боломж бүрдэх ач холбогдолтой юм.

¹ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=14700>

² <https://legalinfo.mn/mn/detail/11634>

³ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=12694>

“Гэмт этгээд шилжүүлэх тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Киргиз Улс хоорондын гэрээ”-г байгуулснаар гарах үр дүн

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон гэмт хэргийг таслан зогсоох чиглэлээрх талуудын хамтын ажиллагааг хөгжүүлэн бэхжүүлэх;
- Гэмт этгээдийг олж тогтоох, шилжүүлэн өгөх, улмаар эрүүгийн хариуцлага хүлээлгэх чиглэлд хоёр улсын хууль хяналтын эрх бүхий байгууллагууд шууд харилцаж, шуурхай хамтран ажиллах;
- Хоёр хууль сахиулах байгууллагууд өөрсдийн нутаг дэвсгэр дээр шалгагдаж байгаа гэмт хэргийн талаар мэдээлэл солилцон харилцан дэмжлэг үзүүлэх зэрэг болно.

Гэрээний үр нөлөө, үр дагаврын талаарх дүн шинжилгээ

Энэхүү гэрээг байгуулснаар Монгол Улсын Их Хурлын 2023 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр (2023-2030)”-ийн⁴ Зорилт 6.2-т “... эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээг бусад улс оронтой байгуулах ажлыг эрчимжүүлж, дотоодын байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулна” гэж заасан зорилтыг хангах чиглэлд үр дүн гарна гэж үзэж байна.

Мөн Монгол Улсад гэмт хэрэг үйлдэн оргон зайлсан гэмт этгээдүүдийг эрэн сурвалжлах, баривчлах, буцаан авчрах замаар ял завших, дахин гэмт хэрэг үйлдэх нөхцөл боломжийг таслан зогсоохын зэрэгцээ хэрэг бүртгэх, мөрдөн шалгах ажиллагаа явуулж буй хэргүүдийг шийдвэрлэх боломж бүрдэх ач холбогдолтой юм.

Гэмт этгээдийг шилжүүлэн өгөхдөө аливаа ялгаварлан гадуурхалт, улс төрийн үзэл бодлынх нь төлөө мөрдөн мөшгих, эрүүдэн шүүх, хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг гутаан доромжлон харьцаж, шийтгэгдэх эсэхийг нягталж, эрсдэлтэй бол шилжүүлэн өгөхөөс татгалзах үндэслэл болгож тусгасан нь хүний эрхийг хангаж, хуулиар хамгаалагдсан хүнийг эрх, эрх чөлөөг хангах боломжийг бүрдүүлсэн.

Түүнчлэн, талууд өөрийн улсын иргэнийг гэмт хэрэгт шийтгүүлэхээр шилжүүлэн өгөхөөс татгалзах зарчмыг гэрээнд тусгасан хэдий ч ял завших нөхцөлийг бий болгохгүй байх үүднээс тухайн иргэнийг харьяалах улсын эрх бүхий байгууллагууд үйлдсэн хэргийг шилжүүлэн авч мөрдөн шалгаж, тохирсон ял шийтгэлийг оногдуулахаар зохицуулсан нь эрүүгийн эрх зүйн үндсэн зарчмуудын нэг болох гэм буруугийн зарчмыг хэрэгжүүлэх явдлыг хангасан байна.

---oOo---

⁴ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16760139781851>